ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/97/-НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn<br>Аудитор Б.Нямдорж<br>Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ..... 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 3
3. Аудитын тайлан ..... 8
 3.1 Ерөнхий зүйл ..... 8
 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 8
 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 9
 3.4 Материаллаг байдал ..... 9
 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 9
 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 10
 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 10
 3.8 Аудитын гол асуудал ..... 10
 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 11
 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 12
 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 12
4. Аудитын илрүүлэлт ..... 12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 14

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28 № 140

танай ________ -ны № ________ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХАЛИУН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.ЭНХТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020259

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I) | 75,406,691.00 | 97,049,331.11 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | (0.00) |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | (0.00) |
| 31210 | Төгрөг | - | (0.00) |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | (0.00) |
| 33 | АВЛАГА | 260,000.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 260,000.00 | - |
| 33101 | Цалингийн авлага | 260,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 75,146,691.00 | 97,049,331.11 |
| 35100 | Түүхий эд материал | 2,023,980.00 | 2,090,500.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,012,000.00 | 2,090,500.00 |
| 35130 | Эм боох материал | 11,980.00 | - |
| 35400 | Хангамжийн материал | 73,122,711.00 | 94,958,831.11 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,194,950.00 | 910,950.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 65,742,911.00 | 74,832,381.11 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 150,000.00 | 150,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,271,850.00 | 656,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,207,400.00 | 8,214,400.00 |
| 35460 | Хүнсний материал | 877,000.00 | 8,516,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,678,600.00 | 1,678,600.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II) | 814,998,571.35 | 679,793,443.18 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 814,998,571.35 | 679,793,443.18 |
| 39200 | Биет хөрөнгө | 770,142,571.35 | 634,937,443.18 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 630,234,974.52 | 515,755,734.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | (103,446,449.01) | (126,602,598.32) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 158,300,686.32 | 172,423,766.32 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (94,231,639.08) | (106,055,591.40) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 56,567,406.88 | 72,485,920.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | (17,198,335.28) | (25,864,132.08) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 167,123,572.00 | 167,943,572.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө | (34,983,075.00) | (43,558,973.40) |
| 39217 | Номын фонд | 7,775,430.00 | 8,409,745.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 44,856,000.00 | 44,856,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,190,000.00 | 1,190,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж | (1,190,000.00) | (1,190,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 44,856,000.00 | 44,856,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II) | 890,405,262.35 | 776,842,774.29 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV) | (0.00) | (0.00) |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | (0.00) | (0.00) |
| 41300 | Өглөг | (0.00) | (0.00) |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | (0.00) | (0.00) |
| 41313 | ХАОАТ-ын өглөг | (0.00) | (0.00) |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V) | 890,405,262.35 | 776,842,774.29 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 890,405,262.35 | 776,842,774.29 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 358,572,526.75 | 358,572,526.75 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 53,934,680.18 | (59,627,807.88) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 53,934,680.18 | 53,934,680.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (113,562,488.06) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 477,898,055.42 | 477,898,055.42 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V) | 890,405,262.35 | 776,842,774.29 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх жилийн дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 795,360,093.00 | 821,002,237.41 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 35,447,389.00 | 11,915,913.41 |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 35,447,389.00 | 11,915,913.41 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 35,447,389.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 35,447,389.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 5,091,843.30 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 6,824,070.11 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 759,912,704.00 | 809,086,324.00 |
| 1310 | Улсын төсвөөс | 704,531,400.00 | 804,811,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 116,460,000.00 | 138,251,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 588,071,400.00 | 666,559,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 20,974,104.00 | 4,274,924.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 20,974,104.00 | 4,274,924.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 34,407,200.00 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 34,407,200.00 | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 836,809,223.30 | 841,435,085.57 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 836,809,223.30 | 841,435,085.57 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 786,697,240.52 | 809,332,019.02 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 480,849,174.21 | 498,879,611.46 |
| 210101 | Үндсэн цалин | 422,517,185.21 | 461,036,090.46 |
| 210104 | Урамшуулал | 41,104,268.00 | 37,843,521.00 |
| 210105 | Гэрээт ажлын цалин | 17,227,721.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 59,477,360.03 | 65,724,195.55 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,745,333.03 | 46,867,162.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 360,000.00 | 4,433,281.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,859,671.00 | 3,795,665.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 948,497.00 | 972,372.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,563,859.00 | 9,655,713.06 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 114,399,297.91 | 127,685,200.44 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,625,697.91 | 1,732,869.44 |
| 210302 | Түлш, халаалт | 111,548,100.00 | 125,637,831.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,225,500.00 | 314,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,958,700.00 | 9,882,350.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 298,750.00 | 489,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,222,200.00 | 2,338,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 250,000.00 | 496,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 520,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 667,750.00 | 6,437,900.00 |
| 2105 | Нормативт зардал | 15,670,610.00 | 14,959,830.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 363,820.00 | 61,980.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,751,790.00 | 14,897,850.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 555,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 18,198,600.00 | 4,243,000.00 |
| 210602 | Тавилга | - | 300,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 160,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 18,038,600.00 | 3,943,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 499,200.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 499,200.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 796,000.00 | 290,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 290,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 91,848,298.37 | 87,667,831.57 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 944,300.00 | 3,335,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 90,903,998.37 | 84,332,731.57 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 50,111,982.78 | 32,103,066.55 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 315,702.09 | 906,523.56 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 314,302.09 | 545,599.56 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,400.00 | 360,924.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 15,061,053.69 | 16,458,742.99 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,061,053.69 | 16,458,742.99 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 34,735,227.00 | 14,737,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 4,500,375.00 | 8,140,100.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 20,974,104.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,260,748.00 | 6,597,700.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 93,129,639.90 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | (41,449,130.30) | (20,432,848.16) |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV) | - | - |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | - | 93,129,639.90 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | - | 93,129,639.90 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 93,129,639.90 |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V) | (41,449,130.30) | (113,562,488.06) |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Бусад | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | ҮЛДЭГДЭЛ | - | - | - | - | - |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - | - | - |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - | - |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - | - |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - | - |
| 8 | ҮЛДЭГДЭЛ | 358,572,526.75 | 477,898,055.42 | 53,934,680.18 | - | 890,405,262.35 |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| 10 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 358,572,526.75 | 477,898,055.42 | 53,934,680.18 | - | 890,405,262.35 |
| 11 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - | - |
| 12 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - | - |
| 13 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| 14 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| 15 | Тайлант үеийн үр дүн | - | - | (113,562,488.06) | - | (113,562,488.06) |
| 16 | ҮЛДЭГДЭЛ | 358,572,526.75 | 477,898,055.42 | (59,627,807.88) | - | 776,842,774.29 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх жилийн дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 769,912,704.00 | 809,086,324.00 |
| 13 | ХАНДИВ, ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 769,912,704.00 | 809,086,324.00 |
| 1310 | Улсын төсвөөс | 704,531,400.00 | 804,811,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 116,460,000.00 | 138,251,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 588,071,400.00 | 666,559,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 30,974,104.00 | 4,274,924.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 30,974,104.00 | 4,274,924.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 34,407,200.00 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 34,407,200.00 | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 759,514,104.00 | 777,568,924.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 759,514,104.00 | 777,568,924.00 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 709,569,471.22 | 743,065,557.45 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 480,023,813.28 | 498,619,611.46 |
| 210101 | Үндсэн цалин | 421,691,824.28 | 460,776,090.46 |
| 210104 | Урамшуулал | 41,104,268.00 | 37,843,521.00 |
| 210105 | Илүү цагийн / Гэрээт ажлын цалин | 17,227,721.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 59,477,360.03 | 65,724,195.55 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,745,333.03 | 46,867,162.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 360,000.00 | 4,433,281.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,859,671.00 | 3,795,665.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 948,497.00 | 972,372.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,563,859.00 | 9,655,713.06 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 115,094,297.91 | 127,206,200.44 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,625,697.91 | 1,732,869.44 |
| 210302 | Түлш, халаалт | 112,243,100.00 | 125,158,831.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,225,500.00 | 314,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,869,600.00 | 4,443,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 298,750.00 | 518,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,359,050.00 | 2,201,350.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 250,000.00 | 496,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,100.00 | 28,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 720,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,121,700.00 | 1,078,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 10,233,800.00 | 23,217,350.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 375,800.00 | 1,425,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,303,000.00 | 19,622,350.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 555,000.00 | 2,170,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 35,878,600.00 | 15,404,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 240,000.00 | 3,080,000.00 |
| 210602 | Тавилга | - | 1,824,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 180,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 35,458,600.00 | 10,500,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 499,200.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 499,200.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 796,000.00 | 290,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 290,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,696,800.00 | 8,160,600.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,696,800.00 | 8,160,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 49,944,632.78 | 34,503,366.55 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 315,702.09 | 906,523.56 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 314,302.09 | 545,599.56 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,400.00 | 360,924.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 15,061,053.69 | 16,458,742.99 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,061,053.69 | 16,458,742.99 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 34,567,877.00 | 17,138,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 4,333,025.00 | 10,540,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 20,974,104.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,260,748.00 | 6,597,700.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II) | 10,398,600.00 | 31,517,400.00 |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 10,398,600.00 | 31,517,400.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 10,398,600.00 | 31,517,400.00 |
| 223 | БУСАД ХӨРӨНГӨ | 10,398,600.00 | 31,517,400.00 |
| 223004 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,398,600.00 | 31,517,400.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V) | (10,398,600.00) | (31,517,400.00) |
| 9 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 10 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | - | - |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII) | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII) | - | - |
| 14 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 15 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Тайлан он | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл |
| **11000 - Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | | - | - |
| **71802 - Ерөнхий боловсрол** | | **804,811,400.00** | **776,104,858.06** |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 804,811,400.00 | 787,807,057.45 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 804,811,400.00 | 787,807,057.45 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 804,811,400.00 | 787,807,057.45 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **508,490,200.00** | **498,619,611.46** |
| 210101 | Үндсэн цалин | 467,776,400.00 | 460,776,090.46 |
| 210104 | Урамшуулал | 40,713,800.00 | 37,843,521.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **67,855,700.00** | **65,724,195.55** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,806,800.00 | 46,867,162.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,915,800.00 | 4,433,281.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,107,500.00 | 3,795,665.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,002,300.00 | 972,372.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,023,300.00 | 9,655,713.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **127,751,800.00** | **127,206,200.44** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,840,000.00 | 1,732,869.44 |
| 210302 | Түлш, халаалт | 125,261,800.00 | 125,158,831.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 650,000.00 | 314,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **45,500,000.00** | **45,486,900.00** |
| 210604 | Урсгал засвар | 10,500,000.00 | 10,500,000.00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 18,500,000.00 | 18,494,900.00 |
| 210602 | Тавилга | 16,500,000.00 | 16,492,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **6,600,000.00** | **6,597,700.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,600,000.00 | 6,597,700.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **12,257,200.00** | **10,540,400.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 12,257,200.00 | 10,540,400.00 |
| **2105** | **Норматив зардал** | **25,257,800.00** | **23,217,350.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,425,000.00 | 1,425,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,357,800.00 | 19,622,350.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,475,000.00 | 2,170,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,130,000.00** | **2,123,750.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 401,000.00 | 400,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 500,000.00 | 496,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 29,000.00 | 28,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,080,000.00 | 1,078,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж** | **966,200.00** | **290,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 966,200.00 | 290,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,800,000.00** | **5,799,600.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,800,000.00 | 5,799,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,202,500.00** | **2,201,350.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,202,500.00 | 2,201,350.00 |
| | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 17,004,342.55 |
| 6 - ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | - | - |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | - | - |
| 620001 | Удирдах ажилтан | - | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | - | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | - | - |
| 620004 | Гэрээт ажилтан | - | - |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлан он |
|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | - | - |
| **71802** | **Ерөнхий боловсрол** | - | **4,274,924.00** |
| **81834** | **Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх** | - | **3,914,924.00** |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 3,914,924.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 3,914,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 3,914,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 118,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 118,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 1,435,000.00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | - | 1,435,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,361,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 2,361,000.00 |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 924.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 924.00 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 3,914,924.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 3,914,924.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | - | 3,914,924.00 |
| **81835** | **Сургуулийн хэвийн үйл ажиллагааг хангах** | - | **360,000.00** |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 360,000.00 |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 360,000.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 360,000.00 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 360,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 360,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | - | 360,000.00 |
| **12000** | **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдох гэсэн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг "Шилэн баланс аудит" ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадалд суралцах чадварт эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж,



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 11 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдлөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 723.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 14.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 11.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 842.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 16.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.4 сая төгрөгөөр тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-ын 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Халиун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.8 хувиар буюу 114.7 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 75.1 сая төгрөгөөс 21.9 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, барилгын засварын материал, хүнсний материал өссөнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 52.1 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 6.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 34.0 сая төгрөгийн материалыг зарцуулж, 2.8 сая төгрөгийн бараа материалыг сумын онцгой комисст өгсөн, хүнсний буцаалт 0.26 сая төгрөгийн бараа материал буцаалт хийсэн байна. бараа материалын үлдэгдэл 97.0 сая төгрөг болж

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,066.0 сая төгрөгөөс 82.9 сая төгрөгөөр буурсан нь 37.2 сая төгрөгийн хөрөнгө авч, 5.1 сая төгрөгийн хөрөнгө хандиваар авч, аймгийн ИТХ-ын тогтоолоор 125.2 сая төгрөгийн барилга, тавилга, машин тоног төхөөрөмжийг данс бүртгэлээс хасаж 983.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 775.7 сая төгрөг болж 0.6 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орлого өмнөх оноос 0.9 хувиар буюу 25.1 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй авсан бараа материал, үндсэн хөрөнгө, орлого өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт байхгүй, тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 116.6 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 943.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 138.3 сая төгрөгөөр бууруулж, 804.8 сая төгрөгөөр баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 804.8 сая төгрөгийн төсөв баталснаас 666.5 сая төгрөгийг улсын төсвөөс 138.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 666.5 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 138.2 сая төгрөг нийт 804.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 787.8 сая төгрөгийг зарцуулж 16.4 сая төгрөгийг улсын төсөвт, 0.5 сая төгрөгийн орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 787.8 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 9.8 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.5 сая төгрөгөөр, норматив зардлыг 2.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 0.7 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 1.8 төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 4.3 сая төгрөгийн гүйлгээ хийгдэн, 2.5 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардал, 1.4 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулж 0.4 сая төгрөг татан төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 144 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 4 мэдээлэл, мэдээлээгүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6


Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 0.8 сая төгрөгийн И-баримтгүй худалдан авалт хийсэн, төрийн сан хяналт тавиагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоног багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."-д гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 22.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгснөөс бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн жилийн аудитаар

- И-баримтын бүрдэл хангалтгүй төрийн сангаар гүйлгээ хийсэн
- Тээвэр шатахууны зардалд хяналт тавих
- Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж байгаа актлах хөрөнгийн судалгааг хянах, ажлын уялдаа холбоотой ажиллах
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16.0 төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11.3 сая төгрөгийн алдааг залруулж, 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1 заалт зөвлөмжийг хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад ИТХ-ын тогтоолоор актлах 10.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасалт хийгээгүй, тооллогоор илүү тоолсон хөрөнгийг залруулсан.

Үнэ төлбөргүй авсан 0.5 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч залруулаг хийв



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**4.2 Төлбөрийн акт**

Эд хогшил худалдан авах зардлаас 0.3 сая төгрөгийн тээврийн зардал төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Сангийн сайдын 2021 оны 190 тоот тушаал Төсвийн зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар; заалттай нийцэхгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Байрны хүүхдийн хоолны зардлыг нормативаас 0.2 мянган төгрөг илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.2. "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" заалт, Засгийн газрын 2019 оны 450 тоот тогтоол Хоолны зардлын норматив тогтоох тухай Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 төгрөгөөр тогтоосугай" заалттай нийцэхгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

**4.3 Албан шаардлага**

Татварын тодорхойлолтоор 0.7 сая төгрөгийн илүү, 2.7 сая төгрөгийн дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Тайлант онд 0.8 сая төгрөгийн И-баримтгүй худалдан авалт хийсэн, төрийн сан хяналт тавиагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."-д оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

**4.4 Зөвлөмж**

Аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хангуулах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 144 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 4 мэдээлэл, мэдээлэлгүй 2 мэдээлэл байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д ".цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-т "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг мөрдөн ажиллах

**2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс: Залруулга | | Үүнээс: Төлбөрийн акт | | Үүнээс: Албан шаардлага | | Үүнээс: Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Халиун сумын Ерөнхий боловсролын сургууль | 8 | 16.0 | 2 | 11.3 | 2 | 0.5 | 3 | 4.2 | 1 | |
| | Дүн | **8** | **16.0** | **2** | **11.3** | **2** | **0.5** | **3** | **4.2** | **1** | |

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын